



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 97

Номгон

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх төсөл,
хөтөлбөрийг санхүүжүүлэх журам баталж,
сонгон шалгаруулах комисс байгуулах тухай

Монгол Улсын жижиг дунд үйлдвэрийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.6, Баянхонгор аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого, аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:


1. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх журмыг нэгдүгээр, төсөл сонгон шалгаруулах комиссыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Жил бүрийн төсвийн төсөлд жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх хөрөнгийг тусгаж, батлагдсан төсвийн дагуу санхүүжүүлэхийг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/, журмын дагуу төслийг хүлээн авч эрэмбэлэх, төслийн явц, эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллахыг “Баянхонгор үйлдвэржилт, хөгжлийн корпораци” ХХК /М.Мөнхбат/ нарт даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР



0117031



ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1 Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг төвлөрүүлж, тэднийг дэмжих замаар эдийн засагт жижиг, дунд үйлдвэрийн эзлэх байр суурийг бэхжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

1.2 Хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг тухайн жилийн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар жижиг, дунд үйлдвэрийг дэмжих чиглэлээр зориулан баталсан төсвөөс олгох ба энэхүү хөрөнгө оруулалт нь аймгийн Засаг даргын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2016-2020 оны үндсэн чиглэлд орсон үйлдвэрлэл, үйлчилгээг өргөтгөх, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд ажлын байр бий болгох боломжийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

1.3 Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд зориулж урт хугацааны хөнгөлөлттэй зээл олгох

1.4 ЖДҮ эрхлэгчдэд санхүүгийн түрээс /лизинг/-ээр үйлдвэрийн тоног төхөөрөмжийг авч ашиглахад дэмжлэг үзүүлэх

1.5 Ажлын байр шинээр бий болгосон ажил олгогчдод зээлийн дэмжлэг үзүүлэх

1.6 ЖДҮ-ийн чиглэлээр дэмжлэг авсан эрхлэгчдийн туршлагыг харилцан солилцуулах

1.7 Төрөөс дэмжлэг авч үйл ажиллагаагаа өргөжүүлсэн, ажлын байр бий болгосон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах, үзэсгэлэн худалдаанд хамруулах

1.8 Зээлийн давхар батлан даалтын үйлчилгээ үзүүлэх

Хоёр. Зээлийн хэмжээ

№	Үзүүлэлт	Аймаг	
		ААНБайгууллага	Хувь хүн
1	Зээлийн хэмжээ	100 сая хүртэл	50 сая хүртэл
2	Зээлийн хүү	Жилийн 2 хувь	Жилийн 2 хувь
3	Зээлийн хугацаа	3 жил	2 жил
4	Үндсэн чөлөөлөгдөх зээлээс	Доод хугацаа 1 жил	
5	Төсөл хүлээн авагч	"Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци" ХХК	

Гурав. Төсөл хүлээн авах

3.1 Төсөл хэрэгжүүлэгчдэд тавигдах шаардлага

3.1.1 Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлтийг хангасан байх

3.1.2 Урьд нь төсөл хэрэгжүүлж байсан бол төсөл нь зорилго зорилтдоо хүрсэн байх

3.1.3 Бизнесийн үйл ажиллагааг нэг жилээс доошгүй хугацаанд эрхэлсэн зохих хэмжээний туршлагатай, зах зээлд тодорхой байр суурь эзэлсэн байх

3.1.4 Татварын болон зээлийн хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх

3.1.5 Шинээр бизнес эрхлэгч нь тухайн төслийн салбартаа мэргэшсэн дадлага туршлагатай хүний нөөцтэй байх

3.1.6 Хуулиар хориглоогүй барьцаа, батлан даалттай байх ба зээлийн барьцаа нь хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, бусдын өмчлөлд шилжүүлж болох эд хөрөнгийн эрх байна.

3.1.7 Тухайн бүтээгдэхүүний түүхий эдийн зах зээлийн судалгаа, үнийн түвшин, хэтийн төлвийн талаарх мэдээлэл, хэрэгцээ шаардлага зэргийг тусгасан шаардлага хангасан төслийг ирүүлэх

3.1.8 Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа явуулахад шаардагдах хүний нөөц, ажлын байрны нөхцлийг бүрдүүлсэн байх

3.1.9 Тухайн хэрэгжүүлэх төслийн хүрээнд шаардлагатай тусгай зөвшөөрөл, техникийн нөхцлийг эрх бүхий байгууллагаас авсан байх

3.1.10 Барьцаалах хөрөнгийг зах зээлийн ханшаар үнэлэх ба нийт үнэлгээний 70%-аар тооцно.

3.1.11 Шинээр бий болох ажлын байранд хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй иргэдээс авах, бүртгэлгүй иргэдийг ажлын байртай болгох бол хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлэх, тухайн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч нийт ажилчдынхаа 10 хувьтай тэнцэхүйц тооны политехникийн оюутнуудыг үйлдвэрлэлийн дадлага хийлгүүлж мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, дадлагажуулах боломжтой талаар төсөлдөө тусгаж баталгаажуулсан байх

3.1.12 Хэрэгжүүлсэн төслийн санхүүжилтийн 30-с доошгүй хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх чадвартай байх, түүнийгээ нотолсон байх

3.1.13 Төслийн үр дүнд бий болох бүтээгдэхүүн үйлчилгээ нь цаашид хөгжих боломжтой, шинэлэг байх

3.1.14 Санхүүжүүлэх бизнес нь тогтмол мөнгөн орлоготой байх

3.1.15 Орон нутгийн онцлогийг харгалзан нутгийн түүхий эдийн нөөцөд түшиглэсэн, үр ашигтай байх

3.1.16 Зах зээлийн судалгаа газар зүйн байрлалыг тусгасан байх /Зэргэлдээ аймаг сумын хэрэгцээг судалсан байх/

3.2 Төсөл хэрэгжүүлэгчийн бүрдүүлэх материал

№	Материал	ААН	Иргэн
3.2.1	ААН-ийн гэрчилгээ	+	
3.2.2	Тусгай зөвшөөрөл	+	
3.2.3	Татварын хэлтсийн тодорхойлолт	+	+
3.2.4	Багийн даргын тодорхойлолт		+
3.2.5	Иргэний үнэмлэхний хуулбар	+	+
3.2.6	Барьцаа хөрөнгийн лавлагаа	+	+

3.2.7	Зээлийн мэдээллийн сангийн лавлагаа	+	+
3.2.8	Орлого нотолсон баримтууд	+	+
3.2.9	Газрын зөвшөөрөл	+	+
3.2.10	Барьцаа хөрөнгийн гэрчилгээ эх хувиар	+	+
3.2.11	Сүүлийн 1 жил санхүүгийн тайланг Аудитаар баталгаажуулсан байх	+	
3.2.12	Журмын 3.1-д заасан шалгуур үзүүлэлтийг хангасан байх	+	+
3.2.13	Хамтран зээл хүсэгч мөн адил бүрдүүлнэ		

Дөрөв. Зээл олгох

4.1 Хөрөнгө оруулалтын мөнгийг төрийн сангийн данснаас “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ний жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжлийн сангийн дансанд шилжүүлж, төсөл хэрэгжүүлэгчийн дансанд төслийн ажлын явц, дараалал, гүйцэтгэлийг үндэслэн үе шаттайгаар санхүүжүүлнэ.

4.2 Тухайн төслийн ашигт ажиллагаа болон хэрэгжүүлэх үе шатыг тооцон зээлийг эхний жил үндсэн зээлийг төлөлтөөс чөлөөлж зөвхөн хүү төлөх эсхүл 3 жилд 20%, 30%, 50%-иар хүүтэй нь хамт төлүүлэхээр гэрээн дээрээ тусгана.

4.3 Төсөл хэрэгжүүлэгч нь хөрөнгө оруулалтын мөнгийг 3 хүртэл жилийн хугацаанд хөрөнгө оруулалтын гэрээний эргэн төлөх хуваарийн дагуу “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжлийн сангийн дансанд тушаана.

4.4 Шалгарсан төсөлд санхүүжилтийг мөнгөн хэлбэрээр олгох бөгөөд шаардлагатай тохиолдолд тоног төхөөрөмж нийлүүлж болно.

Тав. Төслийн сонгон шалгаруулах комисс, түүний үйл ажиллагааны чиглэл

5.1 Аймгийн Засаг даргын дэргэд дарга, дэд дарга, нарийн бичиг, гишүүдээс бүрдсэн орон тооны бус 9 хүний бүрэлдэхүүнтэй “Төсөл сонгон шалгаруулах комисс”-ыг /цаашид комисс гэх/-ыг ажиллуулна.

5.2 Комисс нь иргэн, хуулийн этгээдээс ирсэн төслийн тооноос хамааруулан хуралдааныг тухай бүр зохион байгуулна.

5.3 Комисс нь жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр орж ирсэн төслүүдийн материалтай танилцан хэлэлцэж төсөлд санхүүжилт олгох, эс олгох талаар олонхийн саналаар шийдвэрлэнэ.

5.4 Комиссын гишүүдийн ирц 50 хувиас дээш ирцтэй байж хуралдсан хурлын шийдвэр хүчин төгөлдөрт тооцогдоно.

5.5 Комиссын шийдвэр нь аймгийн Засаг даргын захирамжаар баталгаажна.

5.6 Төслийн мөнгийг эргүүлэн төлөх эцсийн хугацаанд төлбөрийг төлөөгүй барьцааны зүйлийг комиссын шийдвэрийн дагуу үл маргах журмаар хураан авч захиран зарцуулах эрхтэй.

Зургаа. “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци”

ХХК-ийн үйл ажиллагааны чиглэл

- 6.1 Хөрөнгө оруулалтын санхүүжилт хүссэн төслүүдийг хүлээн авах хугацааг тогтоож хэвлэл мэдээллээр олон нийтэд нээлттэй мэдэгдэнэ.
- 6.2 Төслийг хэвлэл мэдээллээр зарласнаас хойш энэхүү журмын 3.2-т дурдсан шаардлагыг хангасан төслийг хүлээн авна.
- 6.3 Иргэн хуулийн этгээд нь төслийн материалыг биеэр болон шуудангаар ирүүлнэ. Төслийн мэргэжилтэн шуудангаар ирсэн төсөлтэй танилцан шаардлага хангаагүй төсөлд ажлын 10 хоногийн дотор хаягийн дагуу болон утсаар хариу өгнө.
- 6.4 Ирсэн төслийн материалын бүрдэлтэд дүн шинжилгээ хийж, шаардлага хангаагүй төслүүдийг хүлээн авахгүй байх ба бүрдэл гүйцсэн материалыг бичиг хэрэг, архив хариуцсан мэргэжилтнээр дамжуулан бүртгэж авна.
- 6.5 Хүлээн авсан материалыг төслийн нэгдсэн бүртгэлийн дэвтэрт бүртгэнэ.
- 6.6 Төсөл хүлээн авах шаардлага хангасан төслүүдэд шинжилгээ, судалгаа хийж төсөл сонгон шалгаруулах комиссын хуралдаанаар оруулахаар бэлдэнэ.
- 6.7 Төслүүдийн талаар боловсруулсан танилцуулга, мэдээллийг комиссын хурал хуралдахаас ажлын 3 хоногийн өмнө комиссын гишүүдэд хүргүүлнэ.
- 6.8 Комиссоос гарсан шийдвэрийг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчтэй Хөрөнгө оруулалтын гэрээ, Барьцааны гэрээг хийх бөгөөд хийгдэх ажлын цаг хугацааны графикийг журамд заасны хавсралтаар хийнэ.
- 6.9 Хөрөнгө оруулалтын гэрээ, барьцааны гэрээг Хууль зүйн хэлтсээр хянуулна.
- 6.10 Гэрээ байгуулснаас хойш ажлын 5 хоногийн дотор эхний санхүүжилтийг олгоно.
- 6.11 Төслийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа болон эргэн төлүүлэх үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэнэ.
- 6.12 Төслийн үйл ажиллагаанд сар тутам хяналт тавих бөгөөд хөрөнгө оруулалтын гэрээ, графикт заасан хугацаанд ажлаа эхлүүлээгүй, гүйцэтгэл дутуу, чанаргүй, чанарын стандартад нийцэхгүй байвал гэрээг цуцлах саналыг комисст танилцуулна.
- 6.13 Төсөл хэрэгжүүлэгч нь хөрөнгө оруулалтын гэрээнд заасан хугацаанд төлбөрөө төлөөгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд нийт төлөгдөөгүй үнийн дүнгээс сарын 0,5 / жилийн 6/ хувиар алданги тооцно.
- 6.14 Төсөл хэрэгжүүлэгчийн гэрээний үүргээ зөрчсөн буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хөрөнгө оруулагчийн санаачлагаар гэрээг цуцалж байгаа тохиолдолд төслийн мөнгийг эргүүлэн төлөх эцсийн хугацааг тодорхой заах бөгөөд шийдвэрт заасан хугацаанд төлбөрийг төлөөгүй барьцааны зүйлийг хураан авах саналыг комисст танилцуулна.

6.15 Аймгийн Засаг даргад хүсэлт гаргаж хөрөнгө оруулалтын төслийн үйл ажиллагааны явц, гүйцэтгэлд дотоод аудит хийлгэж, дүгнэлтийг аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулна.

6.16 Журмын хэрэгжилтийн талаарх мэдээллийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд дараа оны 01 дүгээр сард багтаан танилцуулна.

Долоо. Төсөл хэрэгжүүлэгчийн хүлээх үүрэг, хариуцлага

7.1 Төсөл хэрэгжүүлэгч гэрээ хүчин төгөлдөр болсноор гэрээнд заасан хэмжээний санхүүжилтийн дэмжлэгийг авч зориулалтын дагуу ашиглах;

7.2 Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн санхүүжилтээ авснаас хойш хуанлийн 60 хоногийн дотор үйл ажиллагааг эхлүүлсэн байх ёстой.

7.3 Төслийн санхүүжилтийн дэмжлэгийг зориулалтын дагуу ашиглах, ашиглалтад “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-аас хяналт тавих бүхий л боллоцоогоор хангах.

7.4 Төслийн хугацаанд барьцаа хөрөнгийг дахин үнэлэхэд “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-д хүндрэл учруулахгүй байх.

7.5 Төсөл хэрэгжүүлэгч авсан төслийн зээлээ дуусгахгүйгээр давхардуулж дахин төслийн зээл авахгүй байна.

7.6 Төслийн санхүүжилтийг эргэн төлөх хуваарийн дагуу хугацаанд нь бүрэн төлөх.

7.7 Барьцааны зүйлийн чанар байдал, үнэлгээ муудсан тохиолдолд ЗДТГ шаардсаны дагуу нэмж хөрөнгө барьцаалах

7.8 Барьцааны зүйл нь төслийн санхүүжилтийн мөнгийг бүрэн барагдуулахад хүрэлцэхгүй тохиолдолд бусад хөрөнгөөрөө төлөх

7.9 Төсөл хэрэгжүүлэгч нь үйл ажиллагааны чиглэлийг өөрчилж дахин зээл авахгүй байх

7.10 Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу татвар хураамжийг хугацаанд нь төлөх, Санхүүгийн нэгдсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын дагуу гаргах

7.11 Төслийн санхүүжилийн ашиглалт, үйл ажиллагааны талаарх дараах тайлан мэдээг тогтоосон хугацаанд “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-д ирүүлэх

7.12 Төслийн санхүүжилтийн ашиглалтын талаарх мэдээллийг санхүүжилт олгосноос хойш 1 сарын дотор.

7.13 Санхүүгийн тайланг Татварын албатай тооцоо нийлж тайлант хугацаанаас хойш 1 сарын дотор

7.14 Жилийн тайлан тэнцлийг хөндлөнгийн аудитын байгууллагаар баталгаажуулан татварын албатай тооцоо нийлж, дараа жилийн эхний 2 сарын дотор.

7.15 Бизнес төлөвлөгөөг шинэчлэн гаргасан тухай бүр

7.16 Төсөл хэрэгжүүлэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол цаашид төрийн байгууллагын аливаа тендер болон төсөл хөтөлбөрүүдэд хамрагдах эрхгүй болж Сангийн яамны хар жагсаалтын бүртгэлд бүртгэгдэнэ.

7.17 Төсөл хэрэгжүүлэгч нь энэхүү журам болон гэрээгээр нарийвчлан зохицуулсан үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Найм. Маргаан шийдвэрлэх

8.1 Төсөл хэрэгжүүлэгч гэрээнд заасны дагуу төлбөрийн хуваарийн дагуух төлөлтөө удаа дараа зөрчсөн.

8.2 Төслийн санхүүжилтийг зориулалт бусаар ашигласан

8.3 “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-аас тавих төслийн хэрэгжилтийн хяналтад төсөл хэрэгжүүлэгч саад учруулсан

8.4 Төсөл хэрэгжүүлэгч худал мэдээлэл өгсөн, хуурамч баримт бүрдүүлэн төслийн санхүүжилт авсан

8.5 Төсөл хэрэгжүүлэгч нь хууль тогтоомж, шүүхийн шийдвэр буюу эрх бүхий байгууллагын аливаа шийдвэрийг зөрчсөн

8.6 Төсөл хэрэгжүүлэгчийн бизнесийн үйл ажиллагаа зогссон, эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл хүчингүй болсон


8.7 Төсөл хэрэгжүүлэгч төлбөрийн чадваргүй болсон, дампуурсан тухай шүүхийн шийдвэр гарсан

8.8 Барьцаа хөрөнгийн чанар, үнэлгээ буурсан, төсөл хэрэгжүүлэгч ЗДТГ-т үл мэдэгдэн барьцаа хөрөнгийг өөрчилсөн, захиран зарцуулсан, устгасан, үрэгдүүлсэн

8.9 Барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээ буурсан нөхцөлд төсөл хэрэгжүүлэгч нэмж хөрөнгө барьцаалуулахаас татгалзсан

8.10 Хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэх явцад талуудын үүссэн аливаа маргаантай асуудлыг эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд эс хүрвэл Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 06 дугаар сарын 10-ны
өдрийн 97 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАХ КОМИСС

Комиссын дарга: Г.Батжаргал - Аймгийн Засаг дарга

Комиссын дэд дарга: Н.Оюун-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
төлөөлөгч, Тэргүүлэгч

Нарийн бичгийн дарга: М.Мөнхбат-“Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн
корпораци” ХХК-ний гүйцэтгэх захирал

Гишүүд: Ц.Дашцэрэн -Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Д.Ихбаяр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн
бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

С.Байгалмаа-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн
хэлтсийн дарга

Д.Уранчимэг-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн
дарга

Л.Баясгалангомбо-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын
хэлтсийн дарга

_____оо_____